

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Сургалтын хяналтын зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар 16.5.5 дахь заалт, ЭМСС, СС-ын хамтарсан 2015 оны 97/56 тоот тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалын “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах хүчингүй болгох журам”-ын 4.3, 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Орон тооны бус сургалтын хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга (Б.Мөнхшүр)-д даалгасугай.
3. Уг тушаал батлагдсантай холбогдуулан Ерөнхий захирлын 2022 оны А/30 тоот тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Ж.ОТГОНБААТАР

1606060035



ЭХЭМҮТ-ийн Захирлын 2026 оны ... сарын ...
өдрийн ... тоот тушаалын ...-р хавсралт

**ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ ОРОН ТООНЫ БУС
СУРГАЛТЫН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн дарга: ЭХЭМҮТ-ийн Захирал

Нарийн бичгийн дарга: НЭМ,СМА-ны дарга

Гишүүд: Хүүхдийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал /Хүүхэд судлалын тэнхимийн эрхлэгч/

Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал /Эх барих, эмэгтэйчүүд судлалын тэнхимийн эрхлэгч/

Сувилахуй эрхэлсэн дэд захирал /Сувилахуй судлалын тэнхимийн эрхлэгч/

ЭМТҮЧАБЭА-ны дарга

АХТ-ийн эрхлэгч

Хуульч

Сургалт эрхлэгч сүлжээ байгууллагын төлөөлөл (зөвшилцсөнөөр)

Суралцагч эмч, эмнэлгийн мэргэжилтний төлөөлөл (зөвшилцсөнөөр)

ЭХЭМҮТ-ийн Захирлын 2026 оны ... сарын ... өдрийн
... 10 тоот тушаалын ...-р хавсралт

**ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ ОРОН ТООНЫ БУС
СУРГАЛТЫН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах орон тооны бус сургалтын хяналтын зөвлөл (цаашид “Сургалтын хяналтын зөвлөл” гэх) нь эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын хэрэгжилтэд хяналт тавих, суралцагчийг төгсгөх, сургалтаас хасах, чөлөө олгох, суралцагчаас сонгож сүлжээнд нэгдсэн байгууллагын сул орон тоог нөхөх, сургалтыг сайжруулах талаар санал гаргаж, эрх бүхий албан тушаалтнаар шийдвэрлүүлэх үндсэн чиг үүрэг бүхий төвийн дэргэдэх орон тооны бус зөвлөл байна.
- 1.2 Сургалтын хяналтын зөвлөл нь Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах хүчингүй болгох журам, ЭХЭМҮТ-ийн дотоод журам, Төгсөлтийн дараах сургалтын суралцагчдын дүрэм, журам болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.

Хоёр. Сургалтын хяналтын зөвлөлийн бүтэц үйл ажиллагааны зохион байгуулалт

- 2.1 Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлзүйн мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллагын сүлжээ үүсгэж, сүлжээнд нэгдсэн байгууллага тус бүрийн төлөөлөл, суралцагчийн ба хөндлөнгийн төлөөлөл бүхий орон тооны бус гишүүдээс бүрдэх ба зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргатай ажиллана.
- 2.2 Сургалтын хяналтын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлаас хамаарч холбогдох тэнхимийн сургагч багш, эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийг санал өгөх эрхгүйгээр оролцуулж болно.
- 2.3 Нийгмийн эрүүл мэнд, сургалт, маркетингийн алба нь Сургалтын хяналтын зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын албаны үүргийг гүйцэтгэх ба Сургалтын хяналтын зөвлөлийн нарийн бичгийн даргаар албаны дарга ажиллана.
- 2.4 Сургалтын хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байх ба зөвлөлийн дарга гарын үсэг зурж, тамга дарснаар хурлаас гарсан шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 2.5 Сургалтын хяналтын зөвлөл нь улиралд нэг удаа хуралдах ба шаардлагатай тохиолдолд зөвлөлийн даргын зөвшөөрснөөр ээлжит бус хурал зарлан хуралдуулж болно.
- 2.6 Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүдийн ирц 50 ба түүнээс дээш хувь хүрсэн тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.
- 2.7 Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүн хүндэтгэх шалтгаанаар хуралд ирэхгүй тохиолдолд зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргад өмнө нь мэдэгдэж, хэлэлцэх асуудалтай холбоотой саналаа бичгээр ирүүлнэ.

Сургалтын хяналтын зөвлөлийн нарийн бичгийн даргаас бусад нь санал өгөх эрхтэй байна.

- 2.8 Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүнийг өөр албан тушаалтнаар орлуулахгүй.

Гурав. Сургалтын хяналтын зөвлөлийн даргын чиг үүрэг

- 3.1. Сургалтын хяналтын зөвлөлийн хурал даргалах, хурлыг товлон, дэг, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батална.
- 3.2. Сургалтын хяналтын зөвлөлийн хурлаас гарсан шийдвэр, хурлын тэмдэглэлд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.3. Сургалтын хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батална.

Дөрөв. Сургалтын хяналтын зөвлөлийн нарийн бичгийн даргын чиг үүрэг

- 4.1. Сургалтын хяналтын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг бэлтгэж, зөвлөлийн даргад танилцуулах хурлаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авна.
- 4.2. Сургалтын хяналтын зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулна.
- 4.3. Сургалтын хяналтын зөвлөлийн хурлын тэмдэглэл хөтөлж хурлын гишүүн тус бүрээр гарын үсэг зуруулан зөвлөлийн даргаар баталгаажуулна.
- 4.4. Сургалтын хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, зөвлөлийн даргаар батлуулна.
- 4.5. Сургалтын хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тайланг гарган зөвлөлийн хуралд танилцуулна.
- 4.6. Сургалтын хяналтын зөвлөл, төв, сүлжээ байгууллагуудын төгсөлтийн дараах сургалттай холбоотой үйл ажиллагааны уялдааг зохицуулна.

Тав. Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүний чиг үүрэг

- 5.1. Хурлын тэмдэглэлтэй танилцаж гарын үсэг зурж баталгаажуулна.
- 5.2. Хэлэлцэх асуудалтай холбоотой зөвлөлийн дарга ба бусад гишүүдийг тодруулга мэдээллээр хангана.
- 5.3. Хэлэлцэх асуудалтай холбоотой сонирхлын зөрчилтэй тохиолдолд түүний ил тод мэдээлж, тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохоос татгалзана.
- 5.4. Сургалтын хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад санал өгнө, хэрэгжүүлэхэд үүрэг хүлээж оролцоно.